

МУИС-НШУС-Улс төр судлал За О.Адъяабат

Авилгатай тэмцэж,шударга ёсыг тогтоон бэхжүүлэх нь:

Зорилго:

Нийгэмд газар авсаар буй,нийгмийн хөгжил,дэвшил,ардчиллын үнэт зүйлст асар их хор хохирол учруулж буй “Авилга” хэмээх нийгмийн сөрөг үзэгдлийн эсрэг төр засаг болон иргэдийн хамтын ажиллагаанд тулгуурласан нэгдмэл,урт хугацааны стратегийг хэрэгжүүлэхэд оршино.

Зорилт:

- 1.Нийгмийн зүгээс төр засгийн эрх мэдэл бүхий албан тушаалтнуудад тавих шаардлагыг хүчтэй,үр дүнтэй болгох
2. Төрийн сангийн эх үүсвэрийг үр ашигтай,үр нөлөөтэй зарцуулах,улс төрийн хариуцлагатай байх
- 3.Төр засгийн үйл ажиллагаа ил тод явагдах,иргэдийн хэрэгцээ сонирхолыг мэдрэх,бүх иргэдэд тэгш хандах.

Монгол Улс “Авилгалын эсрэг хууль”-ийг 1996 оны 4-р сард 3 бүлэг 18 зүйлтэйгээр баталсан бөгөөд уг хуулинд зэвсэглэлээр “Авилгал гэж...хээл хахуул авах,хувьдаа материаллаг болон бусад ашиг хонжоо олох зорилгоор албан тушаалын байдал,боломжоо ашиглах,ийнхүү ашилуулахаар түүнд шан харамж,буюу хөнгөлөлт,давуу талыг хувь хүн,хуулийн этгээдээс олгох явдлыг ойлгоно” хэмээн тодорхойлсон. **Авилгал** бол хөшигний цаана явагддаг,авсан,өгсний аль аль нь түүнийг нуухыг зорьдог зэргээс үүдэн нуугдмал шинжтэй байдаг. Авилгал ардчиллын хөгжил цэцэглэлтэнд муу нөлөө үзүүлээд зогсохгүй, ардчиллын замаас ухрахад ч хүргэх аюултай бөгөөд **Монголчуудын** санааг хамгийн ихээр зовоож байгаа асуудал болохын хувьд судлаачид,иргэд,улс төрчид,олон улсын байгууллагуудын анхаарлыг татах болжээ. Авилгалын асуудал төрийн удирдах болон гүйцэтгэх **албан тушаалтнуудтай** холбогдон гардаг онцлогтой.Хувийн

хэвшлийн субъект нь хамгийн оновтой хувилбарыг сонгох туйлын эрмэлзэлтэй байдаг тул **авилгал** авах боломж бараг үгүй. Харин энэ онцлог нь төрийн албан хаагчидтай холбоотой ажил үйлчилгээ явуулахад **авилгал өгөгч болгон** хувиргах боломжтой байдаг байна. **АНУ-ын ОХУА-с хийсэн** “Монгол дахь авилгалын байдалд хийсэн үнэлгээ”судалгаанд авилгал **Монголд** газар авч эхэлж байгаа нь илэрхий байна”хэмээн тэмдэглэж байсан бол,харин МУИС-ийн Азийн судалгааны төвийн санхүүжилтэйгээр хийсэн судалгаанд авилгал **“ноцтой”**байдалд хүрсэн болох нь бодит байдлаас харагдаж байна. Монголын нийгэмд авилгал түгээмэл үзэгдэл болсон.

Төрийн албан тушаалтнуудад хориглох зүйлсийн талаар **авлигын эсрэг хуулинд** хэрхэн тусгагдсныг авч үзвэл хуулийн **7.1.2-т** албан тушаалынхаа бүрэн эрхийн дагуу асуудал боловсруулж,шийдвэрлэхдээ хууль бусаар аль нэг хувь хүн,хуулийн этгээдэд давуу байдал олгох,**7.1.3-т** албан тушаалын хувьд ижил зэрэг дэвийн болон өөрт нь захирагддаг буюу хяналт тавьдаг,албан тушаалтны үйл ажиллагаанд хууль бусаар нөлөөлөх,**7.1.4-т** албан тушаалынхаа байдлыг ашиглан эд хөрөнгө олж авах,давуу эрх эдлэх,хууль бусаар бусдад давуу байдал олгох,бусдын эрхийг хязгаарлах төсвийн болон хандивын хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах, **7.1.5-д** албан тушаалынхаа байдлыг ашиглаж хууль бусаар ашиг хонжоо олох,бусдад давуу байдал олгох зорилготой бусад үйлдэл хийх зэргийг **албан тушаалтнуудад хориглосон байна.Мөн төрийн албаны тухай хуульд** “төрийн албан хаагч албан тушаалын бүрэн эрхээ урвуулан ашиглахыг хориглоно” хэмээн заасан байдаг нь санамсаргүй хэрэг биш ээ. Уг хуульд албан тушаалынхаа бүрэн эрхийг хэрэгжүүлсний төлөө бусад байгууллага,аж ахуйн нэгж иргэнээс мөнгөн шагнал,шан харамж,зээл авах,төлбөргүй болон хөнгөлөлттэйгээр үйлчлүүлэх зэрэг хууль бус бусад хангамж эдлэхийг хориглохоор зохицуулснаараа авилгалын эсрэг гол үзэл санаа,зарчмыг “Төрийн албаны тухай хууль”нь “Авилгалын эсрэг хууль”аас **дутахааргүй хөндсөн гэдэг нь** харагдаж байна.

Төрийн захиргааны албан хаагчид “Эх орон ард түмнийхээ төлөө эрдэм чадлаа зориулж, төрийн хууль, ёсзүйн хэм хэмжээг чанд сахиж, албан үүргээ үнэнч

шударгаар биелүүлэхээ тангараглая.Тангарагаасаа няцвал хуулийн хариуцлага хүлээнэ хэмээн тангараг өргөдөг.

Хэрэгжилт: Хууль тогтоомжинд төрийн алба олон түмэнд ил тод байх,төрийн томилгоо зохих хууль журмын дагуу нээлттэй байх шаардлагыг тусгасан боловч энэ нь **бодит байдалд** хаалттай байсаар байна. Хаалттай байдлын далимдуулан албан тушаал эрх мэдлээ урвуулан ашиглах явдал нийтлэг байна.Төрийн албаны тогтолцоо үйл ажиллагаанд ашиг сонирхолын зөрчилдөөн үүсэх боломж нөхцлийг хязгаарлаж, авилгалын эсрэг **үр дүнтэй эрхзүйн механизмыг эрхзүйт төрийн шаардлагын төвшинд хийж чадахгүй байгаа нь** энэ үзэгдэл төрийн бүх төвшинд тархах гол нөхцөл болсон.

Монголын нийгмийн харилцааны онцлог нь төрийн алба хараат бус,шударга байх явдалд сөргөөр нөлөөлж,нөгөө талаас **Монгол Улсад** төрийн албан хаагчид нь өөрсдийгөө иргэдээс дээгүүр үнэлж,төрийн алба бол олон нийтэд үйлчлэх алба гэсэн сэтгэлгээ хараахан **төлөвшөөгүй**, Монголчууд төрөө дээдэлдэг ард түмэн гэдэг тогтсон ойлголт албан тушаалтнуудад ашигтай байсаар байна.Нийтийн захиргааны эрх мэдлийг урвуулан ашигласан албан тушаалтныг иргэд,иргэний нийгмийн байгууллага шүүхэд өгөх **туршлага** бага, ийм соёл төлөвшөөгүй байгаа нь албан тушаалтнууд хуулиас гадуур,зарим тохиолдолд ил цагаанаар ёс бус үйл ажиллагаа явуулах төрд тодорхой **авилгалын сүлжээ** албан ёсны мэт орших таатай нөхцлийг бүрдүүлж байна. Ажлын албан тушаалд ажилласан хугацаа,үр бүтээл,чадвар туршлагаараа **ахина** гэсэн ойлголт байхгүй мартагдсан зэрэг нь **тохиолдлын хүнийг** өөрийн үзэмжээр төрийн албанд авах, дэвшүүлэх боломжийг бүрдүүлж,хууль ёс дээрээсээ алдагдаж,**төрийн алба арилжааны зүйл болох явдал түгээмэл** хамаатан садан,намын нөхөр,танил тал,,нутаг,1 төгсөлт гэх мэт нэг нь нөгөөгөө өмгөөлсөн харилцаа үүсэж бараг бүх шатанд ашиг сонирхолын зөрчилдөөн даамжирсан нь хариуцлага хяналтын тогтолцоог алдагдуулж,төр бүх төвшиндөө авилгалд автахад хүргэжээ.

Авилгалыг өөгшүүлэгч хүчин зүйлсээс иргэдийн эрх,үүргээ ухамсарладаггүй байдал,хуулийн талаарх мэдээлэл хомс байдаг ба төрийн зүгээс иргэдэд үзүүлэх үйлчилгээний олон талт механизм,түүнээс урган гарах хүнд сурталт тогтолцоо

гэсэн үзүүлэлт байна. **МУИС-ийн Азийн судалгааны төвийн санхүүжилттэйгээр хийсэн судалгаанд** иргэд өөрсдөө эрх, үүргээ төдийлөн сайн мэддэггүй хууль эрхзүйн ойлголт, мэдээлэл хомс байгаа нь авилгалыг газар авахад хүргэж байна гэдэгтэй судалгаанд оролцогчдын **79.5%**, хүнд сурталт тогтолцоо нь авилгалыг өөгшүүлж байна гэдэгтэй **87.6%** нь тус тус санал нийлжээ.

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй эрхзүйн хүчин зүйл:

- Хүнд суртал их байгаа явдал
- Төрийн үйлчилгээний албаны олон шат дамжлага
- Хуулийн мэдлэг нимгэн, иргэд үргэлж бэлэн олз болдог..

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй улс төрийн хүчин зүйл:

- Авилга өгч, улс төрийн өндөр албан тушаалд томилогдох
- Улс төрөөр хөөцөлдөж, эдийн засгийн чадавхаа сайжруулдаг буруу тогтолцоо хэвшил болсон
- Сонгуульд нэр дэвшихийн тулд намдаа өндөр албан татвар төлөх
- Төрийн удирдлагын босоо тогтолцоо
- Мөнгө ба улс төр хэтэрхий хутгалдсан
- **Улс төрийн намын хандив, санхүүжилт авилгалыг өөгшүүлж байна**

Улс төрийн эрх мэдэл, албан тушаал нь мөнгө санхүү, бизнесийн аливаа үйл ажиллагаатай салшгүй уялдаатай болж байгаа нь улс төр бохирдож, хээл хахууль, авилгал улам бүр тархаж. нийгэмд шударга бус явдал гарч байгааг илэрхийлж байна.

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх, өөгшүүлэхэд нөлөөлж буй эдийн засгийн хүчин зүйл:

- Иргэдийн орлогын тэгш бус байдал

- **Өнөөдөр Монголд байгаа** аль ч албан тушаалтны цалин хангамж дэндүү бага байна
- Амьжиргааны чадавхи сул
- .Ажлын байрны эрэлт их
- .Тендерийн шударга бус өрсөлдөөн,тендерийн мэдээллийг маш сул хийдэг
- .Хүний шунал хэтэрснээс

Авилгалыг дэмжин дэлгэрүүлэх,өөгшүүлэхэд нөлөөлж буй зан заншил,ёс суртахууны хүчин зүйл:

- Хүний мөс, нинжин сэтгэл алдарсан
- Хүний шунал нэмэгдэж,гар харах өвчтэй болсон
- .Монголчуудын “**бэлэг**” өгөх дуртай зан нь авилглаыг хүлээн хүлээн зөвшөөрөхөд нөлөөлсөн
- Танилын нүүр халуун гэсэн хууль үйлчилснээр “**танилын маф**”үүсгэдэг.
- Одоо ч хөдөө айлд төрийн тэргүүн очиход морь бэлэглэсээр байгаа.
- Манайхан аль ажил төрлийг хөөцөлдөхөөсөө өмнө хариуцаж буй хүнийг нь сайн таних хүнийг хайж эхэлдэг зуршил тогтсон гэж болно

Авилгатай Тэмцэх Газрын гүйцэтгэсэн “Улс төр,хууль хяналтын байгууллагын хүрээн дэх авлигын эсрэг талаархи төсөөлөл 2009” судалгааны дүнгээс харахад “Улс төрийн хүрээн дэх авилга их түгээмэл буюу 4.54, хууль хяналтын байгууллагад авлига түгээмэл буюу 3.92 хэмээн шинжээчид үзсэн.

Улс төрийн хүрээн дэх авилгад сонгуулийн санхүүжилтийн механизм, нам доторхи болон төрийн албан дахь улс төрийн томилгоо,намын санхүүжилтийн механизм зэрэг хүчин зүйлс голлон хүчтэй нөлөөлж байна.Улс төрийн хүрээн дэх авилгын гол шалтгаан болсон сонгуулийн болон намын санхүүжилтийн механизм,түүнийг дагасан улс төрийн томилгоо нь энэ хүрээний үндсэн оролцогч болох **улс төрийн намууд авилгалд автагдах** үндсэн хүчин зүйл болж байна.Улс төрийн намын өдөр тутмын болон сонгуулийн кампанит ажлыг санхүүгийн эх үүсвэр,төсөв, хөрөнгөгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Өнөөдөр сонгуулиас сонгуулийн хооронд сонгуулийн кампанит ажлын цар хүрээ тэлж,улс төрийн намууд,тэдгээр нэр

дэвшигчдийн сонгуулийн зардал нэмэгдэж, тэр хэмжээгээрээ улс төрчид, улс төрийн намуудын “**хөрөнгө босгол**” буюу хандив мөнгө цуглуулах үйл явц хурдсах, өргөжих хандлага ажиглагдаж байна. Улс төрийн энэ үзэгдлийн сөрөг үр дагавар нь “сонгуулийн кампанит ажлын явцад өр үүсэх нь **Авилгалыг** нэмэгдүүлдэг нь дэлхий дахинд түгээмэл ажиглагдаж / *Шинэ толь 2004:48* /” байгааг тайлбарлагдаж байна.

Сонгуулийн кампанит болон намын санхүүжилтийн ил тод байдал нь:

- Хэн мөнгө өгч байна?
- Хэр хэмжээний мөнгө өгсөн ?
- Хэнд тэр мөнгө очиж байна? Ямар зорилгоор тэр мөнгө ашиглагдав? / *Шинэ толь 2004:49* / гэсэн асуултуудад ямар хариулт ирж буйгаар тайлбарлагдах нь зохистой.

Манай улсад болж өнгөрсөн УИХ-ын удаа дараагийн сонгуулийн үйл явцыг ажиглахад сонгуулийн кампанийн санхүүжилтийн өртөг зардал улам өсөн нэмэгдэх хандлагатай байна. Энд үзүүлсэн зардлын хэмжээ нь зөвхөн албан ёсоор нийтэд мэдээлэгдсэн тоо хэмжээ юм.

УИХ-ын сонгуульд улс төрийн намуудын зарцуулсан зардлын хэмжээ

№	Он	Зардал
1	1992	13 сая 708,2 мянган төгрөг
2	1996	209 сая 349,1 мянган төгрөг
3	2000	1 тэрбум 841 сая 679,8 мянган төгрөг
4	2004	1 тэрбум 558 сая 358,8 мянган төгрөг⁴⁷
5	2008	8 тэрбум 91 сая 164,2 мянган төгрөг⁴⁸

⁴⁷ Монголын Нээлттэй Нийгэм Форум, Сонгогчдын боловсролын төв, Сонгогчдын Глоб Интернешнл 2004. “2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тухай СЕХ-оос нийтлүүлсэн алба ёсны дүн мэдээ” 2004 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн мониторинг тайлан УБ 64

⁴⁸ МУ-ын СЕХ 2008.2008 оны УИХ-ын сонгуулийн кампанит ажлын санхүүжилтийн тайлан УБ


Улс төрийн намын гишүүн нь намд гишүүний татвар, хандив өгөх тухай асуудлыг **“Улс төрийн амын тухай хуулийн 18- зүйлд** “Намд зориулж нэг удаа өгөх хандивын дээд хэмжээ хуулийн этгээдээс 10 сая, иргэдээс нэг сая төгрөгөөс хэтэрч болохгүй бөгөөд нэг хандивлагч, намын нэг байгууллагад жилд 2-оос дээш удаа хандив өгөхийг хориглоно.” Намд хандив өгсний төлөө албан тушаал, хувийн эрх ашгийг хөөцөлдөх, шахалт үзүүлэхийг хориглоно”. хэмээн тусгаж эрхзүйн зохицуулалтын үндсийг зааж өгсөн байдаг. Энэхүү заалт нь манай улс төрчид намууд хандивлагчдаас тодорхой төвшинд өөрийгөө хамгаалах чадвар бүрэлдээгүй байгаа явдлыг харуулж байгаа юм. Тухайлбал хуулийн этгээдээс намд өгч байгаа хандивийг 1 жилд 2 удаа өгч болно гэхээр 20 сая төгрөгийг 1 жилд өгнө. Энэхүү хандиваа сонгуулийн сонгуулийн давтамжаар үржүүлбэл нэг хуулийн этгээд 80 сая төгрөгийг намд өгнө гэсэн үг болж байна. Харин иргэдээс энэ нь 8 сая төгрөг болно. **2007, 2008** оны байдлаар Монгол дахь улс төрийн намуудын гишүүд өөрийн намаас нэр дэвшиж сонгуульд өрсөлдөхийн тулд намдаа өгч байгаа хандивын хэмжээ 20 сая төгрөг байсан бол энэ асуудлыг 80 сая төгрөг болгох боломжтойгоор хуульд заасныг тооцоолон гаргалаа. **Үүнээс үүдээд** нэр дэвшигчид сонгуулийн кампанит ажлын зардлаасаа өмнө нэр дэвших эрхээ олж авахын тулд өөрийгөө санхүүжүүлэх хандивлагчийг хайхгүй гэсэн баталгаа байхгүй. Энэ асуудал нь эргээд сонгогдсон гишүүд нь **ард түмэндээ бус** хандивлагчдаа үйлчлэх гаж гэмээр тогтолцоо бүрдэхэд хүргэж байна. Улс төрийн намын тухай хуулийн 4-р бүлгийн 18-р зүйлд **“нам хандивынхаа талаар нийтэд мэдээлж байна”** мөн 20-р зүйлд “Намын санхүүгийн үйл ажиллагаанд тухайн намын хяналтын байгууллага хяналт тавина. Нам санхүүгийн үйл ажиллагаандаа жил бүр аудит хийлгэн баталгаажуулж, нийтэд мэдээлнэ гэж заасан байдаг. Гэвч өнөөг хүртэл нэг ч нам өөрийн санхүүгийн тайлангаа хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд хүртээл болгоогүй байна.

Улс төрийн **намыг санхүүлэх үйл явц** далд , хяналт байхгүй авлига, хээл хахуулийн шинжтэй болж байна. **Сонгогчдын боловсрол төвөөс явуулсан судалгааны дүнгээс харахад авилгад өртсөн байгууллагуудын жагсаалтанд**

Улс төрийн нам тэргүүлж байна. Улс төрийн намууд авилгад өртөх нь хэр түгээмэл вэ? гэсэн асуултанд нийт судалгаанд оролцогчдийн 37.4% нь түгээмэл 27% нь дунд зэрэг гэсэн хариулт өгсөн байна./ Сонгогчдын боловсрол төв 2003 он /Улс төрийн санхүүжилтийн асуудалд олон нийтийн хяналт,оролцоо байхгүй,гишүүд цөөн хүний хүрээгээр хязгаарлагдаж байгаа нь Монгол байгаа **авилгалын гол эх үндэс гэж дүгнэхэд хүргэж байна.**

Өнөөдөр Монгол улс тэр чигээрээ халамжийн улс болж байгаа нь төрийг данхайлгаж,авилгалын ихэсгэж, ард түмнийг доройтуулж байна.Төрөөс иргэдэд хүргэж байгаа үйлчилгээ нь зөвхөн халамжийн сангийн үйлчилгээгээр хязгаарлагддаггүй бөгөөд **2008 онд** энэ арга хэмжээнд нийт 989.7 тэрбум төгрөг зарцуулж байгаагийн дотор иргэдийн гар дээр шууд мөнгөн хэлбэрээр олгож байгаа нийгмийн хамгааллын зардал 61.5%ийг эзэлж байна.**Сонгуульд бие биетэйгээ “мөнгө”-өөр өрсөлддөг жишиг тогтож,**Намууд хамаагүй юм амлаж өр тавьчихаад салам нэхэгддэг,сонгогчдыг буруу зуршилд дасгаж,сонгуулийг нэг нь мөнгө салгах нөгөө нь өр тавьж хахуульдаж байгаад ч хамаагүй өндөр албан тушаалд хүрдэг арга болтол гажуулдуулсан явдал бол намууд нийгмийн хариуцлагаа алдсны хамгийн том тод жишээ мөн. Судалгааны байгууллагын хийсэн судалгаанаас эрх барьж буй 2 намаас нийгэм юу хүлээж байгааг ач холбогдлоор нь эрэмбэлэхэд эхний **3-т А.**амлалтаа биелүүлж,мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх,**Б.**шударга байх **В.**эх орны хишгийг өгөх гэсэн 3-н асуудлууд орсон байна.

Эх орны хишгийг өгөх эсэхт өгсөн иргэдийн хүлээлт



Эх сурвалж: "Монголын улст төрийн өнөөгийн нөхцөл, байдал сэдэвт судалгаа ММСГ УБ 2009 он 8 сар.

Сүүлийн үед сонгуульд нэр дэвшүүлэх, сонгуулийн үр дүнг харгалзан улс төрийн томилгоо хийх, төр засгийн өндөр албан тушаалд томилогдсон хүмүүс өөрийн багийг бүрдүүлэхэд мэдлэг боловсрол, туршлага дадлага, мэргэжлийн ур чадвар зэргийг **шалгуур биш, харин** улс төрийн намыг хөрөнгө санхүүгээр болон бусад хэлбэрээр дэмжсэн, улс төрчдөд үнэнч зүтгэсэн, нутаг ус, садан төрлийн болон нэг ангид суралцаж байсан зэрэг **албан бус шалгуурыг** урьтал болгодог практик тогтох хандлагатай боллоо. *Удирдлагын академийн судалгааны багаас хийсэн "Төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчийн төлөвшил"* судалгааны тайланд сүүлийн арван жилд төрийн захиргааны мэргэшсэн алба төлөвшлийн байдал арван жилийн өмнөхөөс 21%-аар буурсан гэж үнэлсэн байна. Төрийн захиргааны ажилтнуудын 42.5%-ийг 21-35 насныхан эзэлж буй нь тэднийг мэргэшүүлэх хэрэгцээтэйг, 46%-ийг нь 36-50 насныхан 11.5%-ийг нь 51-ээс дээш насныхан эзэлж буй нь тэднийг давтан сургах хэрэгцээ байгааг тус тус илтгэнэ. **Төрийн албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд тулгардаг гол бэрхшээлд** судалгаанд судалгаанд оролцогсдын 97.1% нь гадаад хэлний мэдлэг, 92.3% нь компьютер интернэт ашиглах чадвар, 88.3% нь албан бичиг баримт боловсруулах чадвар, 82.4% нь харилцааны арга барил дутмаг гэж хариулсан. Энэ судалгаанаас үзэхэд **Төрийн албаны тухай хуульд зааснаар** "төрийн алба мэргэшсэн, тогтвортой" байх хууль эрхзүйн орчинг бүрдүүлсэн боловч түүний

хэрэгжилтийн байдал практик дээр алдагдаж, төр засгийн албанд тушаалд орохдоо улс төрийн намын шууд томилгоо, авилга өгч жилд орж байгаа байдлыг үгүйсгэх үндэсгүй юм. Мөн *Удирдлагын академийн судалгааны багаас хийсэн* “Төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчийн төлөвшил” судалгааны тайланд ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлүүдэд төрийн албан хаагчдын цалин хөлс, хувийн хариуцлага, идэвхи санаачлага, хүмүүсийн ажлыг бодитой үнэлж дүгнэх урамшуулах явдал гэж үзсэн. **Энэ байдал нь төрийн албан хаагчдыг авилгалд өртөгдөх суурь болж байна.**

Авилгалтай тэмцэх алхамууд:

Төрийн захиргааг улс төрийн намын дарангуйллаас салгах: Төрийн захиргааг намын хэт оролцооноос салгахгүй бол авилгатай тэмцэж чадахгүй.

Элекрон засаглалыг нэтрүүлэх: Төрийн байгууллагын хөдөлгөөнгүй босоо тогтолцоог анхан шатны байгууллагын оролцоотой уян хатан сүлжээгээр солих, үйлчлүүлэгч төвтэй үйлчилгээг хөгжүүлэх, ард иргэддээ ил тод, нээлттэй байх явдал юм. **Э-засаглал** хөгжснөөр төрийн байгууллагуудыг хооронд нь холбож мэдээлэл дор бүр нь дамжуулах үүргийг гүйцэтгэнэ. Төрийн байгууллагын хүнд суртал багасч, иргэд нэг байгууллагаас нөгөө байгууллага, нэг албан тасалгаанаас нөгөө албан тасалгаа руу гүйх, гуйх шаардлагагүй болно. Хамгийн гол нь иргэд онлайнаар өргөдөл гомдлоо шийдвэрлэх, тендерт оролцох ба янз бүрийн зөвшөөрлийг авах боломж бүрдэнэ. **Интернэт үйлчилгээний давуу тал нь** иргэдээс авилга нэхэхгүй, **бүх нийтийн хяналтан дор ил тод** ажиллаж чаддагт байгаа юм. **Судалгаанаас үзэхэд** хүмүүсийн мэдээлэл авдаг үндсэн сувгуудын дотор телевиз давамгайлж байгаа ч интернэт гэх мэт бусад сувгийн нөлөө өсч байгаа аж. **2003** онтой харьцуулахад **2008** онд интернэтийн хэрэглээ **3.5** дахин нэмэгдсэн. Ялангуяа нийслэл **УБ** хотын иргэдийн дунд интернэтийн хэрэглээ эрчимтэй нэмэгдэж, дийлэнхи хувь нь ямар нэг байдлаар **интернэт** хэрэглэж байгаа юм. **Өмнөд солонгос** Э Засаглалыг ашиглаж авилгатай тэмцснээр авилгалыг 49% бууруулсан байна.

Иргэдийн оролцоо ба хяналтыг хөгжүүлэх:

Монголын ард түмэн ардчилсан нийгмийг “**төрийг ардчилах**” явдал хэмээн ойлгож байснаас иргэний нийгмийг хөгжүүлэх тухай ойлгож байсангүй. Тиймээс ч өнгөрсөн **рхи**илийн турш улс төр, эдийн засгийн шинэтгэлд түлхүү анхаарч харин иргэний боловсролыг орхигдуулжээ. Төрийн бодлого боловсруулах шийдвэр гаргах бүхий л үйл явцад иргэд оролцох боломж олдсонгүй. Боломж олдоогүй нь иргэдийн оролцоог дэмжих хууль эрхзүйн орчин бүрдээгүйтэй холбоотой Монголын төрийн захиргаа хаалттай ажилладаг тухай **ганц жишээ хэлэхэд 2006 онд Монгол Улс “нээлттэй төсвийн индекс”** хэмээх олон улсын харьцуулсан судалгаанд хамрагдсан дэлхийн **59 орноос** хамгийн хаалттай **10 орны нэгээр** тодорчээ.

Иргэддээ төсвийн талаар мэдээлэл өгдөггүй, тул төсөв

боловсруулах, хэлэлцэх, батлах, тайлагнах үйл явцад иргэд оролцох боломжгүй аж. Хамгийн товчоор хэлэхэд иргэд өөрсдийнхөө өгсөн мөнгийг төр хэрхээн яаж зарцуулж байгаад хяналт тавьж чадахгүй байна.

Дүгнэлт: Чухамхүү олон нийтийн оролцоо хяналт бол төрийг цэвэр ариун байлгах /авилгалгүй /хамгийн хүчирхэг механизм юм. Мэдээлэлтэй, мэдлэгтэй ард түмэн шударгаа ёсыг жинхэнэ утгаар хэрэгжүүлдэг. Үүнийг тулд бидэнд Мэдээллийн эрх чөлөөний тухай хууль нэн тэргүүнд хэрэгтэй байна. Цаашилбал УИХ ба засгийн газрын түвшинд бодлого боловруулахад иргэдийг түлхүү оролцуулах, санал бодлыг нь тусгах иргэдийн хяналтыг ажиллуулах, бүтцүүдийг хөгжүүлэхгүйгээр авилагтай тэмцэж, шударга ёсыг тогтоон бэхжүүлж чадахгүй, Авилгал хээл хахууль болон бусад олон сөрөг үр дагавруудын гол шалтгаан болсон улс төрийн намуудын санхүүжилтийн тайланг заавал ил тод, нээлттэй болгох шаардлагатай. Гол анхаарлыг шинэ шинэлэг санаа санаачлагад нь бус харин нийтлэг зорилгод /шударга ёсыг тогтоон бэхжүүлэх / хүрэхэд удирдагчид болон иргэд хамтран ажиллаж тогтвортой харилцан уялдсан хүчин чармайлт гаргах явдал болно.

Ашигласан эх сурвалж:

- 1.С.Энхсайхан** “Төрийн бүтээмжийн удирдлага” УБ 2010 он
- 2.Ч.Сосормаа** “Төрийн захиргаанаас нийтийн захиргаа руу”УБ 2008 он
- 3.Ардчилалыг шинээр болон сэргээн тогтоосон орнуудын Олон Улсын 5-р**
бага хурал УБ 2003 он
- 4.МУИС-Орчин үеийн улс төрийн судалгааны төв** “Авилгалыг Дэмжигч ба
Хориглогч хүчин зүйлс УБ 2007 он
- 5. ”Политологи – 5”** эрдэм шинжилгээний бичиг УБ 2009 № 325 (51)
- 6.Ардчилсан засаглалын шалгуур үзүүлэлтүүд:** Монгол дахь засаглалын төлөв
байдал,үнэлгээ УБ 2006 он